



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь боловсролын зорилго, зарчим, тогтолцоо, боловсролын харилцаанд оролцогчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Боловсролын хууль тогтоомж

2.1.Боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 3.1.1."ерөнхий боловсрол" гэж бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсролыг;
- 3.1.2."боловсролын агуулга" гэж боловсролын тухайн түвшинд суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, төлөвшлийн цогцыг;
- 3.1.3."боловсролын түвшин" гэж сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг;
- 3.1.4."багц цаг" гэж боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг;
- 3.1.5."зайн сургалт" гэж боловсролын агуулгыг суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;
- 3.1.6."мэргэжлийн чиглэл" гэж мэргэжил эзэмших хөтөлбөрийн ангиллыг;
- 3.1.7."насан туршийн суралцахуй" гэж хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг;
- 3.1.8."албан боловсрол" гэж боловсролын сургалтын байгууллагаар дамжуулж, эрх бүхий байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу суралцагчийн боловсрол эзэмших, үр дүнг боловсролын баримт бичгээр баталгаажуулдаг зохион байгуулалттай үйл ажиллагааг;
- 3.1.9."албан бус боловсрол" гэж иргэн, хуулийн этгээдээс хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;
- 3.1.10."амьдралын орчинд суралцахуй" гэж хүний ажил, амьдрал, нийгмийн орчинд бие даан чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;
- 3.1.11."суралцагч" гэж боловсролын сургалтын байгууллагад албан ёсоор суралцаж байгаа хүнийг;
- 3.1.12."сургалтын орчин" гэж сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг;
- 3.1.13."сургалтын хөтөлбөр" гэж суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшил, зорилго, зорилт, үнэлгээ, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичгийг;
- 3.1.14."төлөвшил" гэж хүмүүжил, хандлага, эрхэмлэх үнэт зүйлийг;

3.1.15."мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц" гэж хүний эзэмшсэн чадвар, чадамжийг ангилан төрөлжүүлж, түвшнээр нь эрэмбэлсэн бүтцийг;

3.1.16."хувьсах зардал" гэж сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэг суралцагчид ногдох шууд болон шууд бус өртөгт суурилсан зардлын дундаж хэмжээг;

3.1.17."цахим сургалт" гэж цахим технологи ашиглан зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;

3.1.18."цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага" гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг;

3.1.19."боловсролын үнэлгээ" гэж боловсрол, сургалтын үйл ажиллагааны явц, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэх, баталгаажуулах, цахим технологи ашиглан тайлагнах үйл явцыг;

3.1.20."чанарын баталгаажуулалт" гэж боловсрол, сургалтын чанарыг хууль тогтоомжид заасан шаардлага, чанарын шалгуур, стандартад нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх, сайжруулах, үр дүнг баталгаажуулах үйл явцыг;

3.1.21."хөндлөнгийн үнэлгээ" гэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаас үнэлэх үнэлгээг;

3.1.22."магадлан итгэмжлэл" гэж боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанар нь эрх бүхий байгууллагаас тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэхэд мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх үйл явцыг;

3.1.23."эндаументын сан" гэж дээд боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ашиг олох зорилгогүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийг;

3.1.24."ялгаатай хэрэгцээ" гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.

4 дүгээр зүйл.Боловсролын зорилго

4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

5 дугаар зүйл.Боловсролын зарчим

5.1.Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх бөгөөд бодлого, үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.1.1.үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан байх;

5.1.2.тогтвортой, уялдаатай, уян хатан байх;

5.1.3.тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх;

5.1.4.төр, олон нийтийн оролцоог хангасан, хамтын хариуцлагатай байх;

5.1.5.насан туршийн суралцахуйг дэмжсэн байх;

5.1.6.мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн байх;

5.1.7.улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

5.1.8.хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх.

5.2.Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтална.

6 дугаар зүйл.Боловсрол эзэмшүүлэх сургалтын хэл

6.1.Монгол Улсад боловсрол эзэмшүүлэх сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. Сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байх бөгөөд эх хэлээрээ суралцах болон бусад гадаад хэл суралцах эрхийг үл хөндөнө.

6.2.Зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан боловсролын сургалтын байгууллага гадаад хэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж болно.

6.3.Боловсролын сургалтын байгууллага энэ хуулийн 6.4-т заасан агуулгыг монгол хэлээр эзэмшүүлэхээс гадна тухайн боловсролын сургалтын байгууллагын төлөвлөгөөнд заасан гадаад хэлийг судлахад энэ хуулийн 6.1 дэх хэсэг хамаарахгүй.

6.4.Энэ хуулийн 6.2-т заасан боловсролын сургалтын байгууллага суралцагчид монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийн агуулгыг заавал монгол хэлээр эзэмшүүлнэ.

6.5.Сонсголын бэрхшээлтэй суралцагчид боловсрол эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан дохионы хэлээр явуулна.

7 дугаар зүйл.Боловсролын тогтолцоо

- 7.1.Боловсролын тогтолцоо нь албан, албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцахуйгаас бүрдэнэ.
- 7.2.Албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол гэсэн түвшинтэй байна.
- 7.3.Иргэний амьдралын орчинд суралцахуйг хүлээн зөвшөөрч, үр дүнг баталгаажуулж болно.
- 7.4.Албан болон албан бус боловсролын агуулга, стандартыг энэ хуульд заасны дагуу тогтооно.

8 дугаар зүйл.Боловсрол эзэмшүүлэх сургалтын хэлбэр

- 8.1.Сургалт нь танхимын, танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрийн зохион байгуулалттай байна.
- 8.2.Танхимын бус сургалтад зайн, хувилбарт болон цахим, дадлага сургалт хамаарна.
- 8.3.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно.
- 8.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт энэ хуулийн 8.1-д зааснаас гадна хосмог болон ажлын байрны сургалтын хэлбэртэй байж болно.

9 дүгээр зүйл.Боловсролын болон сургалтын баримт бичиг

- 9.1.Боловсролын баримт бичиг нь суралцагчийн эзэмшсэн боловсролын түвшин, мэргэжил болон чадамжийн түвшнийг гэрчилсэн албан ёсны баталгаа мөн.
- 9.2.Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, үнэмлэх, техникийн болон дээд боловсрол эзэмшсэн төгсөгчид диплом олгоно.
- 9.3.Боловсролын болон сургалтын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 9.4.Сургалтын баримт бичиг суралцагчийн бүртгэл, мэдээлэл, багшийн журнал байна. Сургалтын баримт бичиг нь цахим хэлбэртэй байж болно.
- 9.5.Гадаад улсын боловсролын болон сургалтын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан хүлээн зөвшөөрөх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 9.6.Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх, багц цаг тооцох журмыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 9.7.Суралцагч нь тухайн түвшний боловсролын агуулгыг бүрэн эзэмшээгүй тохиолдолд аливаа боловсролын баримт бичиг олгохгүй.
- 9.8.Боловсролын баримт бичиг цаасан болон цахим хэлбэртэй байна.

10 дугаар зүйл.Суралцагчийн эрх, үүрэг

- 10.1.Суралцагч дараах эрхтэй:
 - 10.1.1.эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах;
 - 10.1.2.уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд эх хэлээрээ харилцах;
 - 10.1.3.чадамжаа үнэлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, дүйцүүлэх, баталгаажуулах;
 - 10.1.4.сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;
 - 10.1.5.суралцагчийн өөрийн удирдлагын байгууллагаар дамжуулан боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцох;
 - 10.1.6.сургалтын чанар, сургалтын хөтөлбөр, агуулгын талаар санал, хүсэлт илэрхийлэх, судалгаа, шинжилгээний ажилд оролцох;
 - 10.1.7.хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;
 - 10.1.8.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;
 - 10.1.9.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах;
 - 10.1.10.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сорилд хамрагдахгүй байх;
 - 10.1.11.ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах;
 - 10.1.12.хуульд заасан бусад.

10.2.Суралцагч дараах үүрэгтэй:

- 10.2.1.сургалтын хөтөлбөр, агуулгыг эзэмших;
- 10.2.2.багш, ажилтны хууль ёсны шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;
- 10.2.3.багш, ажилтан, суралцагч, хамт олны харилцааг эрхэмлэх, бусдыг хүндэтгэх;
- 10.2.4.боловсролын сургалтын байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 10.2.5.ерөнхий боловсролыг заавал эзэмших;
- 10.2.6.бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх;
- 10.2.7.хуульд заасан бусад.

11 дүгээр зүйл.Суралцагчийн нийгмийн баталгаа

- 11.1.Цэцэрлэг, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид ногдох хувьсах зардлыг төр хариуцна.
- 11.2.Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид сургуулийн автобусаар үйлчилж болно.
- 11.3.Гадаадын болон дотоодын мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно.
- 11.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгож болно.
- 11.5.Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгоно.
- 11.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн, дэмжих үйлчилгээгээр хангагдана.
- 11.7.Холбогдох хууль тогтоомжид заасан бусад баталгаагаар хангагдана.

12 дугаар зүйл.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

- 12.1.Багш, ажилтан нь боловсролын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 12.3.Энэ хуулийн 12.2-т заасан дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.
- 12.4.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, багш мэргэжлийн сонгон бүлэг зохион байгуулах журам, сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 12.5.Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр багшийг бэлтгэнэ. Багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшаар ажиллаж болно.
- 12.6.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр энэ хуулийн 5.1.4-т заасан зарчимд үндэслэсэн, Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандартад нийцсэн байна.
- 12.7.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ.
- 12.8.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.
- 12.9.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.8-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно.
- 12.10.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд тухайн түвшний боловсролын сургалтын байгууллага болон багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн боловсролын харилцаанд оролцогч талуудтай хамтран зохион байгуулна.
- 12.12.Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна.
- 12.13.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 12.14.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцон тухайн аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны боловсролын

сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

12.15.Энэ хуулийн 12.14-т заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах хугацаа, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.16.Багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангийн суралцагчийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн сул орон тоонд Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

12.17.Багш үндсэн ажлын цагаас бусад цагт өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж, нэмэлт орлого олж болно. Энэ харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

13 дугаар зүйл.Багшийн эрх, үүрэг, багш, ажилтны нийгмийн баталгаа

13.1.Багш дараах эрхтэй:

13.1.1.эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;

13.1.2.судалгаа шинжилгээний ажил хийх;

13.1.3.жил тутам холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;

13.1.4.боловсролын сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх болон шийдвэр гаргахад санал өгөх;

13.1.5.хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;

13.1.6.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;

13.1.7.цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах;

13.1.8.хуульд заасан бусад.

13.2.Багш дараах үүрэгтэй:

13.2.1.суралцагчид тогтоосон хугацаанд сургалтын хөтөлбөр, агуулгыг чанартай, бүрэн эзэмшүүлэх;

13.2.2.суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;

13.2.3.суралцагчийн чадамжийг бодитой үнэлэх, тэдний авьяас, хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг судлан суралцахуйг дэмжих;

13.2.4.суралцагчийн төлөвшил, хувийн зан чанарыг судлах, сонирхол, сайн тал, авьяас, чадварыг илрүүлэх, хөгжүүлэн дэмжих;

13.2.5.суралцагчаа хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх;

13.2.6.хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, суралцагчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх, суралцах арга барилыг дэмжих;

13.2.7.багшийн мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, нэр төрийг эрхэмлэх;

13.2.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

13.2.9.сургалтад цахим технологи, хэрэглэгдэхүүнийг үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад цахим системийг ашиглах;

13.2.10.ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндэтгэх;

13.2.11.суралцагчийн эрхийг зөрчих болон сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, багш, удирдах ажилтан хууль тогтоомжоор хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулах үйлдэл гаргахгүй байх;

13.2.12.байгууллагын үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, бусад багш, ажилтан, суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

13.2.13.улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;

13.2.14.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;

13.2.15.суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.16.ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.17.суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.2.18.хуульд заасан бусад.

13.3.Багш, ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

13.3.1.хөдөлмөрийн онцлогийг харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15 өдөр, багш, багшийн туслах, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт олгох;

13.3.2.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан багш нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг авах;

13.3.3.сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;

13.3.4.төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;

13.3.5.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.6.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлтэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах.

13.4.Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

13.5.Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага нь багшийг сургалтын үйл ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалаар хангана.

13.6.Багш, ажилтны ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

13.7.Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан нэмэгдэл амралт энэ хуулийн 13.3.1-д заасан албан тушаалтанд хамаарахгүй.

13.8.Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, буцалтгүй тусламж авсан багш, ажилтныг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд үргэлжлүүлэн ажиллуулах тохиолдолд энэ хуулийн 13.3.3 дахь заалт хамаарахгүй.

13.9.Боловсролын болон хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас бусад чиг үүргийг багшаар гүйцэтгүүлэхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР, АГУУЛГА, СТАНДАРТ

14 дүгээр зүйл.Албан боловсролын хөтөлбөр, агуулга

14.1.Албан боловсролын агуулга нь суралцагчийн нас, хөгжлийн онцлог, авьяас, сонирхол, хувь хүний болон нийгмийн хэрэгцээ, үндэсний соёл, өв уламжлал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

14.2.Албан боловсролын агуулгыг мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын, дипломын, бакалавр, магистр, докторын гэж ангилах бөгөөд агуулгыг сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

14.3.Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын хөтөлбөр, агуулгатай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

14.4.Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ:

14.4.1.монголын түүх, монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшил;

14.4.2.хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл;

14.4.3.хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал;

14.4.4.иргэний ёс зүйн болон зан төлөвийн боловсрол;

14.4.5.эрүүл мэндийн боловсрол;

14.4.6.хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол;

14.4.7.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан;

14.4.8.ажил мэргэжлийн чиг баримжаа олгох;

14.4.9.мансууруулах бодис, сэтгэгдэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршиг, дэлгэцийн донгоос сэргийлэх талаар.

14.5.Боловсролын сургалтын байгууллага нь шинжлэх ухаан, соёл урлаг, спортын байгууллагатай хамтран бүх түвшний сургалтын хөтөлбөр, агуулгын дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж болно.

14.6.Гадаад улсад монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, боловсрол нөхөн эзэмших сургалт зохион байгуулах, монгол хүний хөгжлийг дэмжих зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг байгуулж болно.

14.7.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгын мөрдөх хугацаа нь батлагдсанаас хойш ерөнхий боловсрол эзэмшүүлэх хугацаагаар тогтвортой байна.

14.8.Цахим сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 14.2-т заасан хөтөлбөрт үндэслэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

14.9.Бүх түвшний албан боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах агуулгыг зөвхөн энэ хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл.Албан бус боловсролын хөтөлбөр, агуулга

15.1.Албан бус боловсролын агуулга нь иргэний хэрэгцээнд нийцсэн, нээлттэй байх ба сургалтын зохион байгуулалт нь уян хатан байна.

15.2.Ерөнхий боловсролын агуулгыг нөхөн эзэмшүүлэхэд албан боловсролын сургалтын хөтөлбөрийг баримтална.

15.3.Албан бус боловсролын сургалтыг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага бүртгэж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлнэ.

16 дугаар зүйл.Боловсролын стандарт

16.1.Боловсролын стандартаар сургалтын орчин, эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн ажил мэргэжлийн чадамж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих үндсэн шаардлагыг тодорхойлно.

16.2.Боловсролын стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага батална.

16.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байр, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дадлага сургалтад хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчинд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасан холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА, ТЭДГЭЭРИЙН АНГИЛАЛ

17 дугаар зүйл.Боловсролын байгууллага

17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн, боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвөөс бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь, хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүйн болон сургалт эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.3.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллага нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохирц, нийцлийг шалган турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага энэ хуулийн 17.4-т заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг сонгон туршилт зохион байгуулж болно.

17.6.Насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Насан туршийн суралцахуйн төв нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд байна.

17.7.Насан туршийн суралцахуйн төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг төлбөргүй зохион байгуулна.

17.8.Энэ хуулийн 17.6-д заасан төв нь танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлж болно.

17.9.Боловсролын, эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төв

ажиллуулж болно.

17.10.Энэ хуулийн 17.9-д заасан дэмжих төвийн үйл ажиллагааны зардлыг боловсролын, эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран санхүүжүүлнэ.

17.11.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.12.Энэ хуулийн 17.11-д заасан үнэлгээ, элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.13.Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага нь боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг эрхлэн хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.14.Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага нь магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.9-д заасны дагуу гадаадын хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, гадаад улсын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах, бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

17.15.Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд боловсролын зэрэг, баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.

18 дугаар зүйл.Боловсролын сургалтын байгууллага

18.1.Боловсролын сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургууль байна.

18.2.Боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус, эсхүл ашгийн төлөө байж болно.

18.3.Ашгийн төлөө, ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-д заасан үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

18.4.Боловсролын сургалтын байгууллага төрийн, орон нутгийн, хувийн болон холимог өмчийн хэлбэртэй байна.

18.5.Боловсролын сургалтын байгууллага өөрийн үндсэн чиг үүрэгт нийцсэн сургалт, судалгаа, туршилт, үйлдвэрлэл явуулах орчин нөхцөлийг бүрдүүлсэн бүтэцтэй байна.

18.6.Боловсролын сургалтын байгууллага шашны сургалт, шашны зан үйл, холбогдох бусад үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

18.7.Энэ хуулийн 18.6 дахь хэсэг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд заасан шашны сургуульд хамаарахгүй.

18.8.Боловсролын цахим сургалтын байгууллагыг энэ хуульд заасан шаардлагын дагуу байгуулж болно.

18.9.Гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургууль нь хөтөлбөр хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоо, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тайлагнана.

19 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

19.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан этгээд байгуулж болно.

19.2.Боловсролын сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий этгээд олгоно.

19.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

19.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

19.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний сургалтын хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

20 дугаар зүйл.Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, түүнд тавих шаардлага

20.1.Энэ хуулийн 19.1-д заасан этгээд зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан болон дараах баримт бичгийг

сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ:

- 20.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдийн гэрээ, танилцуулга;
- 20.1.2.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах хүний нөөц, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;
- 20.1.3.стандарт, техникийн зохицуулалтад заасан шаардлага хангасан хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, дадлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;
- 20.1.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;
- 20.1.5.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх мөнгөн болон бусад хөрөнгийн жагсаалт, хэмжээ, баталгаа, эзэмшил газрын зөвшөөрөл;
- 20.1.6.шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа;
- 20.1.7.ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан баримт бичиг, сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын байгууллагад нийт багшийн 90-ээс доошгүй хувьд мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад нийт багшийн 80-аас доошгүй хувьд мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг;
- 20.1.8.цэрэг, цагдаа, төмөр замын мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын санал;
- 20.1.9.боловсролын сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, ял шийтгэл хүлээж байсан эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
- 20.1.10.татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүй тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.

20.2.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад шилжүүлж болно.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан эрх хүлээн авагч Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гарган эрх шилжүүлсэн байгууллагад тайлагнана.

20.4.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргана.

20.5.Мэргэжлийн, техникийн, дээд боловсролын шинэ мэргэжлийн, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх зөвшөөрлийн хүсэлт гаргахад Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичиг болон энэ хуулийн 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.1.8, 20.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх үйл ажиллагааны танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс таваас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

20.6.Энэ хуулийн 19.1-д заасан этгээд хуульд заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийн хамт үнэн зөв бүрдүүлэн эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

20.7.Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ мэргэжлээр сургалт эрхлэх хүсэлтийг шийдвэрлэхэд энэ хуулийн 20.5-д заасан хугацаа хамаарахгүй.

21 дүгээр зүйл.Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

21.1.Сургуулийн өмнөх, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас доошгүй байна. Ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрлийн хугацаа 12 жил байна.

21.2.Зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

21.3.Энэ хуулийн 20.1.10-т заасан татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй тохиолдолд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.

22 дугаар зүйл.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

22.1.Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

- 22.1.1.үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;
- 22.1.2.зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- 22.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

22.1.4.нийт суралцагчийг боловсролын сургалтын өөр байгууллагад шилжүүлсэн;

22.1.5.хуульд заасан бусад.

22.2.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдох эд хөрөнгийн харилцааг Иргэний хуульд заасны дагуу зохицуулна.

22.3.Татан буугдсан боловсролын сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох баримт бичгийг орон нутгийн болон үндэсний төв архивт хүлээлгэн өгнө.

22.4.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах шийдвэрийг тухайн хичээлийн жилтэй уялдуулж суралцагчийн сурах эрхийг хөндөхгүйгээр эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

23 дугаар зүйл.Боловсролын удирдлагын тогтолцоо

23.1.Боловсролын удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын үндэсний зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, боловсролын байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролын сургалтын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

23.2.Боловсролын сургалтын байгууллагын удирдлага нь тухайн байгууллагын гүйцэтгэх удирдлага болон өөрийн удирдлага байна.

23.3.Боловсролын үндэсний зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд Мэргэжлийн зөвлөл, Судалгааны ёс зүйн дэд хороо, ажлын албатай байна. Ажлын албаны даргын чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга хэрэгжүүлнэ.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан Боловсролын үндэсний зөвлөл нь боловсролын бодлого, хэрэгжилт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийн талаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж чиглэл гаргах, боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа, судалгааны тохирц, бүтээлийн хулгайгаас сэргийлэх, багш, судлаач, эрдэмтэн, төрийн бус байгууллага, ажил олгогчийг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоо, тэдгээрийн хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

23.5.Энэ хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Мэргэжлийн зөвлөлд мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх чиг үүргийг энэ хуулийн 23.3-т заасан ажлын алба хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

24.1.Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/ боловсролыг хөгжүүлэх, дэмжих талаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.энэ хуулийн 11.3, 11.4, 11.5-д заасан тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх журмыг баталж, хэмжээг тогтоох;

24.1.2.энэ хуулийн 13.3.2, 13.3.3, 13.3.4-т заасан нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг, мөнгөн тэтгэмж олгох журмыг батлах;

24.1.3.энэ хуулийн 17.11, 17.13-т заасан байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

24.1.4.төрийн өмчийн олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллага, түүний харьяаллын сургууль, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хамтарсан сургууль байгуулах, өөрчлөх, татан буулгах шийдвэр гаргах;

24.1.5.сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, олон улсын хөтөлбөр, тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлэх цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд боловсрол эзэмшүүлэхэд хүүхдийн тоо, хэрэглээний үнийн түвшингээс хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр, хувьсах зардал болон үр дүнгийн үнэлгээнд үндэслэн төсөв тооцох аргачлал, санхүүжүүлэх журмыг батлах;

24.1.6.төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын хувьсах зардлын хэмжээг хоёр жил тутам шинэчлэн тогтоох;

24.1.7.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хувь, хэмжээг тогтоох;

24.1.8.боловсролын цахим мэдээллийн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

- 24.1.9.Боловсролын үндэсний зөвлөл байгуулах, бүрэлдэхүүн, дүрмийг батлах;
- 24.1.10.мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг батлах;
- 24.1.11.энэ хуулийн 38.8-д заасан дэмжлэг үзүүлэх, буцалтгүй тусламж олгох журам батлах;
- 24.1.12.энэ хуулийн 25.1.3-т заасан жагсаалтыг батлах;
- 24.1.13.боловсролын цахим мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг батлах;
- 24.1.14.энэ хуулийн 12.7, 12.10-т заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх журмыг батлах;
- 24.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

25 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

25.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 25.1.1.боловсролын хөтөлбөр, норм, нормативын хэрэгжилт, боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах;
- 25.1.2.гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншил зааж сургахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 25.1.3.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийг тодорхойлох аргачлал, жагсаалтыг таван жил тутам шинэчлэн боловсруулж батлуулах;
- 25.1.4.иргэнд боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, боловсрол, мэргэжлийг дээшлүүлэх талаар бусад байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагааг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах;
- 25.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

26 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

26.1.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 26.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 106.3-т заасны дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын жишиг норм, нормативыг батлах;
- 26.1.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам батлах;
- 26.1.3.иргэнийалбан бус боловсрол болон амьдралын орчиндсуралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;
- 26.1.4.төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах;
- 26.1.5.сурах бичгийн эхийг зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагыг батлах;
- 26.1.6.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежер, арга зүйч, багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг батлах;
- 26.1.7.мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын мэргэжлийн чиглэл, индексийг батлах;
- 26.1.8.хуульд өөрөөр заагаагүй бол мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага батлах;
- 26.1.9.энэ хуулийн 17.2, 17.11, 17.13-т заасан байгууллагын бүтэц, дүрмийг батлах;
- 26.1.10.энэ хуулийн 17.2, 17.11, 17.13-т заасан байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасны дагуу чөлөөлөх;
- 26.1.11.зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам батлах;
- 26.1.12.гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед боловсролын салбарын бэлэн байдлыг хангах, гамшгийн нөхцөл байдлыг харгалзан хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаанд зохицуулалт хийх шийдвэр гаргах;
- 26.1.13.аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны журмыг батлах;
- 26.1.14.багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох бусад үйл ажиллагааны журмыг батлах;
- 26.1.15.боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрмийг батлах;

- 26.1.16.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоог энэ хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн тогтоох;
- 26.1.17.Төрийн албаны тухай хуулийн 57.14-т заасан төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг салбарын онцлог, гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэмэгдүүлэх асуудлыг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэх;
- 26.1.18.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;
- 26.1.19.боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын бүтэц, орон тоог тухайн нутаг дэвсгэр дэх суралцагчийн тоо, төвөөс алслагдсан байдлыг үндэслэн батлах;
- 26.1.20.боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлах;
- 26.1.21.боловсролын сургалтын байгууллагад олгох зөвшөөрлийн гэрчилгээний загварыг батлах;
- 26.1.22.мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт, төгсөлтийн журам, элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал батлах;
- 26.1.23.боловсролын чанарын баталгаажуулалт хийх журам, аргачлал батлах;
- 26.1.24.боловсролын салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбоотой санал боловсруулах, салбарын холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон шаардлагатай дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;
- 26.1.25.энэ хуулийн 17.9-д заасан төвийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааны дүрмийг эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран батлах;
- 26.1.26.хуульд заасан бусад бүрэн эрх.

27 дугаар зүйл.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

- 27.1.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 27.1.1.сурах бичиг зохиох, хэвлэх, ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж бодисоор хангах, төлөвлөгөө хэрэгжүүлэх;
- 27.1.2.багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх;
- 27.1.3.аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;
- 27.1.4.боловсролын болон сургалтын баримт бичгийг хэвлүүлэх, түгээх, олгох ажлыг зохион байгуулах;
- 27.1.5.улсын олимпиад, мэргэжлийн болон техникийн боловсролын ур чадварын уралдаан зохион байгуулах журам, ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам баталж мөрдүүлэх;
- 27.1.6.боловсролын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, тайлан, статистикийг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, холбогдох хуульд заасны дагуу мэдээлэх;
- 27.1.7.гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, хэлбэр өөрчлөх тохиолдолд сургалтын тасралтгүй байдлыг хангах хариу арга хэмжээ авах нэгдсэн зохицуулалт хийх;
- 27.1.8.энэ хуулийн 14.6-д заасан төвд дэмжлэг үзүүлэх журмыг батлах;
- 27.1.9.сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалт батлах;
- 27.1.10.аймаг, нийслэлийн насан туршийн суралцахуйн төвийн захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;
- 27.1.11.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд ашиглах ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагыг батлах;
- 27.1.12.хуульд заасан бусад бүрэн эрх.

28 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага

- 28.1.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлд боловсролын газар, нийслэлийн дүүрэгт боловсролын хэлтэс байна.
- 28.2.Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 28.2.1.боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- 28.2.2.хичээл, судлагдахууны агуулга, арга зүй, үнэлгээ, технологи болон зайн, цахим сургалтыг хөгжүүлэх, сургалтын чанар,

үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

28.2.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.6, 7.7-д заасан зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах;

28.2.4.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх;

28.2.5.өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах;

28.2.6.иргэнд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах, насан туршдаа суралцахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

28.2.7.өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад хоол хүнсний хангамж, сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохирох орчныг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

28.2.8.сургуулийн орчинд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, боловсролын сургалтын байгууллагыг арга зүй, зохицуулалтаар хангах;

Тайлбар:Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3.1.4-т заасан "сургуулийн орчин" гэсэн тодорхойлолтод бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин хамаарна.

28.2.9.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын гамшгийн эрсдлийг үнэлэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авах, нөхцөл байдлыг тогтворжуулахад хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

28.2.10.гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоох тохиолдолд боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;

28.2.11.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, албан хаагч ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

28.2.12.орон нутгийн насан туршийн суралцахуйн төвтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

28.2.13.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн биелэлт, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

28.2.14.зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

28.2.15.хуульд заасан бусад.

28.3.Нийслэлийн боловсролын газар нь дүүргийн боловсролын хэлтсийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлага, дэмжлэгээр хангаж ажиллана.

28.4.Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

28.4.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан, эсхүл нийгмийн ажилтнаар таваас доошгүй жил ажилласан, магистр зэрэгтэй байх;

28.4.2.боловсрол судлал, багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн, төрийн болон боловсролын удирдлага, төлөвлөлт, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ, нийгмийн ажил, сэтгэл зүйн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн байх.

28.5.Дүүргийн боловсролын хэлтсийн дарга нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

28.5.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан, эсхүл нийгмийн ажилтнаар таваас доошгүй жил ажилласан байх;

28.5.2.энэ хуулийн 28.4.2-т заасан шаардлагыг хангасан байх.

28.6.Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

28.7.Нийслэлийн боловсролын газрын дарга дүүргийн боловсролын хэлтсийн даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

28.8.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно.

29 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;

29.1.2.орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих;

29.1.3.орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин, сургалтын чанарыг сайжруулахад шаардагдах төсвийг жил бүр батлах;

29.1.4.насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, санхүүжилтийг батлах;

29.1.5.боловсролын салбарын барилга байгууламжийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчны стандартад нийцсэн талбайн хэмжээний дагуу газрын нөөцөд авч, газар зохион байгуулалтын холбогдох төлөвлөгөөнд тусгах;

29.1.6.хуульд заасан бусад.

30 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

30.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;

30.1.2.боловсролын сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

30.1.3.насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

30.1.4.нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний цөөнхийн монгол хэл болон эх хэлээрээ боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

30.1.5.орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг Засгийн газар болон иргэн, олон нийтийн өмнө хариуцах;

30.1.6.боловсролын сургалтын байгууллагын нийт албан хаагчийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээг авах;

30.1.7.боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авах;

30.1.8.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газрыг зориулалтын барилга байгууламжаар хангах;

30.1.9.ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид сургуулийн автобусаар үйлчлэх журам батлан, үйл ажиллагааг зохион байгуулах;

30.1.10.орон нутаг дахь насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны болон тогтмол зардлыг санхүүжүүлэх, хамтран ажиллах;

30.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

31 дүгээр зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

31.1.Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.хүүхдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх, иргэнд ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг дэмжих, хамтран ажиллах;

31.1.2.иргэнд насан туршийн суралцахуйн талаарх мэдээллээр хангах, хамтран ажиллах, арга хэмжээ авах;

31.1.3.өмчийн хэлбэр үл харгалзан боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

31.1.4.өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

31.1.5.насан туршийн суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг баталж, санхүүжүүлэх, хамтран ажиллах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;

31.1.6.тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

31.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

32 дугаар зүйл.Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

32.1.Баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны хүүхдийн боловсрол эзэмших үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

32.1.2. нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдийн сургууль завсардалт гаргахгүй байх, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх;

32.1.3. тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

32.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

33 дугаар зүйл. Боловсролын сургалтын байгууллагын удирдлага, түүний чиг үүрэг

33.1. Өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээдийн томилсон гүйцэтгэх удирдлага удирдана. Гүйцэтгэх удирдлага нь цэцэрлэгт эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургуульд захирал, их сургуульд проректор, ректор байна.

33.2. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч дараах тусгай шаардлагыг хангасан байна:

33.2.1. багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр энэ хуулийн 27.1.2-т заасан мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, төгссөн байх;

33.2.2. боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар зургаагаас доошгүй жил, тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх.

33.3. Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.3.1. тухайн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангах;

33.3.2. тухайн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх;

33.3.3. тухайн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, суралцагчийг удирдан чиглүүлэх, тасралтгүй хөгжлийг хангах, үнэлэх, дэмжлэг үзүүлэх;

33.3.4. суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сурлагын амжилт чанарыг сайжруулахын тулд багшид шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

33.3.5. суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

33.3.6. сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах;

33.3.7. хуульд заасан бусад.

33.4. Энэ хуулийн 28.4, 28.5-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага, 33.2-т заасан албан тушаалд тавих тусгай шаардлагыг хангаагүй иргэнийг томилохыг хориглоно.

33.5. Энэ хуулийн 33.2-т заасан шаардлагыг энэ хуулийн 17.1 дэх хэсэг, 25, 28 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцож болох бөгөөд дүйцүүлэн тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

34 дүгээр зүйл. Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага

34.1. Мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургууль, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль болон Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулсан боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага нь удирдах зөвлөл байна.

34.2. Энэ хуулийн 34.1-д зааснаас бусад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн өөрийн удирдлага нь сургууль, цэцэрлэгийн зөвлөл байна.

34.3. Цэрэг, цагдаагийн мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагад энэ хуулийн 34.1 дэх хэсэг хамаарахгүй бөгөөд чиг үүргийн онцлогт нийцсэн захиргааны зөвлөлтэй байна.

34.4. Энэ хуулийн 34.3-т заасан захиргааны зөвлөлийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна.

34.5. Энэ хуулийн 34.2-т заасан зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

34.6. Энэ хуулийн 34.1, 34.2-т заасан боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдах байгууллагын чиг үүрэг, төлөөлөл, бүрэн эрхийн хугацааг холбогдох хуулиар зохицуулна.

35 дугаар зүйл. Боловсролын хяналт шалгалт, чанарын үнэлгээ

35.1. Боловсролын хяналт шалгалтыг холбогдох хуульд заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

35.2. Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагч боловсролын болон холбогдох хууль тогтоомж,

захиргааны хэм хэмжээний акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавина.

35.3.Боловсролын чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох журмын дагуу энэ хуулийн 17.11-д заасан байгууллага, суралцагч, эцэг, эх, иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөллийг оролцуулан зохион байгуулна.

35.4.Боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийг хөндлөнгөөс үнэлнэ.

35.5.Боловсролын үнэлгээг цахимаар зохион байгуулж болох ба суралцагчийн ахиц дэвшилд дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах цахим системтэй байна.

35.6.Боловсролын чанарыг гурван жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлнэ.

35.7.Боловсролын сургалтын байгууллага дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

35.8.Боловсролын сургалтын байгууллага энэ хуулийн 35.7-д заасан чанарын баталгаажуулалтын үр дүнд үндэслэж, чанарын сайжруулалтын төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ.

35.9.Энэ хуулийн 35.8-д заасан төлөвлөгөө нь боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний хэсэг болох бөгөөд түүний ажлын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь чанарын ахиц дэвшил байна.

35.10.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гадаад улсын хөтөлбөрийг магадлан итгэмжилнэ.

35.11.Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын магадлан итгэмжлэлийг холбогдох хуулиар зохицуулна.

35.12.Сургалтын хөтөлбөрийг гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжилж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРГАЛТЫН ОРЧИН

36 дугаар зүйл.Боловсролын төлөвлөлт, тайлагналт

36.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан бодлого, төлөвлөлтөд үндэслэн аймаг, нийслэл нь боловсролыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

36.3.Боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 26.1.1-д заасан норм, нормативд нийцсэн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

36.4.Энэ хуулийн 36.1, 36.2, 36.3-т заасан этгээд боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалт болон нөөцийг хуваарилах, сургалтын байгууллага байгуулах, бүтэц, хамран сургах тойрог тогтооход хүн амын нягтаршил, суурьшил, дэд бүтэц, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулсан газар зүйн мэдээллийн системд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

37 дугаар зүйл.Боловсролын санхүүжилт

37.1.Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ.

37.2.Боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагааны онцлогоос хамаарч дараах нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй байна:

37.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд холбогдох хуулиар зөвшөөрсөн төлбөр, хандив, тусламж;

37.2.2.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсөв, сургалтын төлбөр, эндаументын сан болон эрдэм шинжилгээ, инновацын төсөлт ажлын санхүүжилт;

37.2.3.цэрэг, цагдаагийн дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад төсвөөс санхүүжүүлсэн зардал, эрдэм шинжилгээний төсөлт ажлын санхүүжилт;

37.2.4.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь үүсгэн байгуулагчийн хөрөнгө, хувьсах зардал, сургалтын төлбөр, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрийн санхүүжилт;

37.2.5.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид олгох сургалтын шууд өртөгт суурилсан зардлын санхүүжилтийн хэмжээг байршил, сургалтын төлбөрийн хэмжээтэй уялдуулан Засгийн газар тогтоох бөгөөд санхүүжилт авах суралцагчийн тоогоор олгох.

37.3.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага улсын төсөв, эрдэм шинжилгээний төсөлт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжнэ.

37.4.Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн сургалтын орчин, үйл ажиллагааг дэмжсэн туслах аж ахуйтай байж болох

бөгөөд түүнээс олсон орлогоо зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч хэрэгжүүлнэ.

37.5.Боловсролын сургалтын байгууллага энэ хуулийн 37.1, 37.4-т заасан өөрийн орлого бүрдүүлсэн нь төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг бууруулах үндэслэл болохгүй.

37.6.Боловсролын сургалтын байгууллага сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журмыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

38 дугаар зүйл.Боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт

38.1.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн үйл ажиллагааны дараах зардлын бүрэлдэхүүнийг харгалзан тооцож, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:

38.1.1.сургуулийн хүчин чадлаас хамаарсан үйл ажиллагаа, үл хөдлөх эд хөрөнгө болон үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, байр ашиглалтын болон тогтмол зардал, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал;

38.1.2.хүүхдийн тоо, бүлэг дүүргэлт, хүчин чадлын ашиглалт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, нэмэлт хөтөлбөр, багшийн мэргэжлийн хөгжил, сургалтын цахим хэрэглээ, сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, боловсролын стандарт, багш ажилтны дундаж цалин хөлснөөс хамаарсан сургалтын үйл ажиллагааны хувьсах зардал;

38.1.3.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллын санхүүжилт;

38.1.4.холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байгаа үдийн хоол болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх зардал;

38.1.5.багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зардал.

38.2.Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

38.3.Энэ хуулийн 38.1.3-т заасан нэмэлт урамшууллын санхүүжилтийг олгоход боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээ нь сургалтын чанар, суралцагч бүрийн суралцахуйн үр дүнд гаргасан ахиц, тухайн байгууллагын засаглал, ил тод байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн талаар хийсэн хөндлөнгийн үнэлгээнд үндэслэх бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

38.4.Энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно.

38.5.Улсын төсвөөс дараах зардлыг санхүүжүүлнэ:

38.5.1.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид олгох хувьсах зардал;

38.5.2.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дотуур байрны багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан санхүүжилт;

38.5.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байрны нийт зардал, төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хувьсах зардал, хоолны зардал, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогтмол зардал;

38.5.4.цэцэрлэгт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоол, сургуулийн суралцагчийн дотуур байрны хоолны зардал;

38.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хэсэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хоолны зардал;

38.5.6.төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардал;

38.5.7.төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын зориулалттай тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, анхны өртгийг харгалзан нэг хүүхдэд тухайн жилд ногдох элэгдлийн зардлыг тооцсон дундаж норматив зардлаар санхүүжүүлэх тоног төхөөрөмжийн нөхөн хангалт, ашиглалтын зардал;

38.5.8.өмчийн хэлбэр үл харгалзан дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид хуульд заасан нөхцөлөөр төрөөс олгох тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, зээл;

38.5.9.цэцэрлэгийн хүчин чадал, бүлэг дүүргэлтээс шалтгаалан үндсэн сургалтад хамрагдаагүй хоёр настай хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших хувилбарт сургалтын хэлбэрээс сонгосон тохиолдолд олгох гүйцэтгэлд суурилсан хувьсах зардал;

38.5.10.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, наадгай, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн баяжилт;

38.5.11.үндэсний хэмжээнд нэвтрүүлэх суралцагч бүрийн сурлагын ахиц, үр дүнг илэрхийлэх цахим систем нэвтрүүлэлт, хөгжүүлэлт, ашиглалт, аюулгүй байдлыг хангах зардал;

38.5.12.энэ хуулийн 17.7, 17.8, 17.9-д заасан үйлчилгээ болон албан бус сургалтын зардлын тодорхой хэсэг;

38.5.13.урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн тусгайлан тодорхойлсон захиалгат хөтөлбөрийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэл, үр дүнд суурилсан сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний зардлын тодорхой хэсэг.

38.6.Энэ хуулийн 38.5.5, 38.5.6, 38.5.7-д заасан зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг Засгийн газар тогтоож, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгана.

38.7.Төрөлжсөн хичээлийн улсын олимпиад зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч олон улсын түвшний шинжлэх ухааны олимпиадад оролцох болон төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх дугуйлангийн зардлын тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

38.8.Нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, бүс, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээнд үндэслэн мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяас, чадварыг дэмжих, зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгоно.

38.9.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.

38.10.Энэ хуулийн 38.5.1-д заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

39 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагын орчин

39.1.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлог тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

39.2.Энэ хуулийн 39.1-д заасан орчны норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсролын, эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

39.3.Боловсролын сургалтын байгууллагыг зориулалтын барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сурах бичиг, дотуур байраар хангах асуудлыг үүсгэн байгуулагч хариуцна.

39.4.Боловсролын сургалтын байгууллага өөрийн харьяанд сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно.

39.5.Боловсролын сургалтын байгууллага нь барилга, хот төлөвлөлтийн норм, нормативыг баримтлан тогтоосон, сургалтад зориулсан эзэмшил газартай байна.

39.6.Энэ хуулийн 39.5-д заасан эзэмшил газар болон боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглана.

39.7.Энэ хуулийн 29.1.5-д заасны дагуу шинээр барих сургууль, цэцэрлэгийн газрыг өөр зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах, худалдахыг хориглоно.

39.8.Боловсролын сургалтын байгууллага нь болзошгүй эрсдэл, гамшгаас хамгаалах аюулгүй байдлыг хангасан, суралцагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн орчин бүрдүүлсэн байна.

39.9.Боловсролын сургалтын байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад хуульд заасны дагуу тэгш боломж олгосон, хүртээмжтэй, хувь хүний хөгжил, сурч боловсрох хэрэгцээ шаардлагыг хангасан таатай орчин бүрдүүлсэн байна.

39.10.Төрөөс боловсролын хүртээмж, суралцах тэгш нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээг улсын болон орон нутгийн төсөв дэх ачааллыг бууруулж, үе шаттай шийдвэрлэх зорилгоор дараах нөхцөлөөр хөрөнгө оруулалтын элэгдлийн зардлыг нэг хүүхдэд ногдох норматив тогтоон жил бүр санхүүжүүлж болно:

39.10.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг арилжааны хөнгөлөлттэй нөхцөлөөр лизинг болон түрээсийн гэрээгээр хоёр буюу түүнээс дээш жилийн хугацаатай эзэмших, ашиглах, худалдан авах зардал;

39.10.2.бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын цахим сургалтын орчныг бүрдүүлэх тоног төхөөрөмж, хатуу болон зөөлөн дэд бүтцийн сүлжээ ашиглалт, түүнтэй холбогдох засвар үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан түрээсийн болон лизингийн гэрээний үндсэн дээр ашиглах, эзэмших, худалдан авах зардал;

39.10.3.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж багатай, нэмэлт элсэлт авах боломжгүй байршилд аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан сургалтын зориулалтаар барьсан барилга, байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон зардал.

БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИЙН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

40 дүгээр зүйл.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг

40.1.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах эрхтэй:

40.1.1.хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, хөгжлийн талаар багш болон боловсролын сургалтын байгууллагаас зөвлөгөө авах, хамтран ажиллах;

40.1.2.хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах;

40.1.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн болон энэ хуулийн 34.2-т заасан сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох;

40.1.4.боловсролын сургалтын байгууллага, багшийн үйл ажиллагааны талаар санал, хүсэлт гаргах;

40.1.5.сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчин, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан боловсролын болон сургалтын баримт бичигтэй танилцах;

40.1.6.хуульд заасан бусад.

40.2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах үүрэгтэй:

40.2.1.гэр бүлийн орчинд сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах;

40.2.2.хүүхдийг таван настайд нь сургуулийн өмнөх боловсролд, цаашид ерөнхий боловсролд заавал хамруулах;

40.2.3.сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгсэлтэй холбоотой зардлыг хариуцах;

40.2.4.хүүхдийн нас, хөгжлийн онцлог, зан төлөвийг таньж мэдэх, хүүхдээ ойлгон хүндлэх, туслах, хараа хяналтгүй орхихгүй байх;

40.2.5.сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан сургуулиас тавьсан холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн шаардлагыг биелүүлэх;

40.2.6.багшийн нэр хүндийг гутаан доромжлохгүй байх, хүндэтгэлтэй хандаж, соёлтой харьцах;

40.2.7.хүүхдийнхээ хөгжил, төлөвшил, эрүүл мэнд, аюулгүй байдалд байнгын анхаарал тавих, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, дүрэмт хувцсаар хангах;

40.2.8.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиас зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, багш, суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

40.2.9.энэ хуулийн 38.5.5-д заасан зардлын тодорхой хэсгийг хариуцах;

40.2.10.хуульд заасан бусад.

40.3.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч боловсролын сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах бөгөөд гэрээний загварыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

41 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг

41.1.Хуулийн этгээд дараах эрхтэй:

41.1.1.мэргэжилтэн бэлтгүүлэх, ажилтны мэргэжлийг дээшлүүлэх захиалгыг холбогдох боловсролын сургалтын байгууллагад өгөх, гэрээ байгуулан сургах;

41.1.2.боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчин бүрдүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хуульд нийцсэн хандив өгөх;

41.1.3.хуульд заасан бусад.

41.2.Хуулийн этгээд дараах үүрэгтэй:

41.2.1.гэрээний дагуу суралцагчийг үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, бололцоогоор хангах, дагалдангаар ажиллуулах;

41.2.2.байгууллагын ажилтны мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах;

41.2.3.энэ хуулийн 41.2.2-т заасан сургалт зохион байгуулах зардлыг хариуцах;

41.2.4.хуульд заасан бусад.

42 дугаар зүйл.Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны эрх, үүрэг

42.1.Боловсролын харилцаанд оролцогч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дараах эрхтэй:

42.1.1.салбарын хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, хэлэлцүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд оролцох, санал, зөвлөмж өгөх;

42.1.2.хамтарсан судалгаа хийх, сургалт зохион байгуулах;

42.1.3.боловсролын салбар, хүний нөөц, техник, технологийн хөгжил дэвшил, чанар, хүртээмж зэрэг чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах;

42.1.4.хуульд нийцүүлэн зарим чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлэх;

42.1.5.боловсролын чанарын үнэлгээ, баталгаажуулалт болон багшийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцох;

42.1.6.хуульд заасан бусад.

42.2.Боловсролын харилцаанд оролцогч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо нь дараах үүрэгтэй:

42.2.1.мэргэжлийн түвшинд боловсролын үйл ажиллагаанд оролцох;

42.2.2.судалгаанд суурилсан мэдээлэл, баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглах;

42.2.3.энэ хуулийн 42.1.4-т заасан гэрээт ажлыг мэргэжлийн хэмжээнд, хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах;

42.2.4.оюуны өмчийн эрхийг хүндэтгэх;

42.2.5.боловсролын үйл ажиллагаанд оролцоходоо улс төрийн болон хувийн ашиг сонирхол илэрхийлэхгүй байх;

42.2.6.багш ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээг авах талаар зөвлөмж хүргүүлэх;

42.2.7.гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;

42.2.8.хуульд заасан бусад.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, САН

43 дугаар зүйл.Боловсролын цахим мэдээллийн сан, дэд бүтэц

43.1.Боловсролын салбарт боловсролын цахим мэдээллийн сантай байх бөгөөд тус сан нь төрийн мэдэлд байна.

43.2.Иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих суралцахуйн удирдлагын системтэй байна.

43.3.Боловсролын цахим мэдээллийн сан бүх түвшний боловсролын сургалтын байгууллага, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн болон төсвийн мэдээллээс бүрдэнэ.

43.4.Боловсролын цахим мэдээллийн сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг боловсролын цахим мэдээллийн сан хариуцсан байгууллага хариуцна.

43.5.Боловсролын цахим мэдээллийн нөөц сантай байна.

43.6.Боловсролын цахим мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

43.7.Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

44 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

44.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

45 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

45.1.Энэ хуулийн 28.4, 28.5, 33.2 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.